



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/168

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Казак түмний Наурыз баярыг тохиолдуулан аймаг, орон нутгийн бүтээн байгуулалт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан нэр бүхий иргэдийг нарыг Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 210000 төгрөг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 210000 төгрөг /Хоёр зуун арван мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 19-ний өдрийн
А/168 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ БОЛОН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Х.Ырымхан	Ховд сумын Дунд-Ус баг	30000
2	С.Колдыбек	Ховд сумын Дунд-Ус баг	30000
3	А.Авдынадыр	Жаргалант сум Рашаант баг	30000
4	Д.Хуаныш	Жаргалант сум Рашаант баг	30000
5	С.Серкхан	Жаргалант сум Рашаант баг	30000
6	Ч.Аманбол	Жаргалант сум Рашаант баг	30000
7	А.Жылхыбай	Жаргалант сум наран баг	30000
Дүн			210000

-оОо-